

Төлөвлөлт, тайлагналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Пүрэвжав Наранжаргал

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээ болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнана.							
1	Боловсролын салбарт мөрдүүлэхээр батлагдсан Монгол Улсын хууль, Улсын Их хурлын тогтоол, Улсын Их хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны	Хугацаандаа хүргүүлсэн тайлангийн нийт тайланд эзлэх хувь	2023 оны гүйцэтгэл	Боловсролын салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт хугацаандаа ХШҮДАГ-т хүргэгдсэн байна.	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр буюу Монгол Улсын хууль, Улсын Их хурлын тогтоол, Улсын Их хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын 2023 оны жилийн эцсийн болон 2024 оны 2,3,4, 5, 6, 7, 8, 9 дүгээр сарын тус бүр 256 заалт, хагас жилийн 548 заалтын хэрэгжилтийн тайланг яамны нэгжүүдээс Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан буюу http://meds.igovernment.mn системээр дамжуулан авч арга хэмжээ бүрээр нэгтгэн боловсруулж хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлэн ажилласан. Шинээр батлагдсан тогтоол шийдвэрийн биелэлт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

	тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийг сар, улирал, хагас бүтэн жилээр тайлагнах, системд тайлан оруулах эрхийн зохицуулалт хийх				тайлагнах газар, хэлтсүүдэд системээр хувиарлах ажлыг хийж гүйцэтгэсэн. 2.Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан буюу http://meds.igovernment.mn системд Сайдын шуурхайн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд оруулж ажилласан. Дараах хөтөлбөр, төлөвлөгөөний тайлан биелэлтийг гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн. 1."Хүний эрхийг хангах арга хэмжээний төлөвлөгөө"-ний биелэлт, 2."Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөнд /2023-2027/ боловсролын яам болон харьяа байгууллагын хэрэгжүүлэх зорилтын тайлан", 3."Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээний төлөвлөгөө (2023-2024 он)-ний биелэлт 4. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт 5."Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх" арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 6. Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө – V 2024-2027 Монгол Улс нээлттэй засгийн түншлэлийн амлалт, зорилтот үйл ажиллагаануудын хэрэгжилт 7."Эрүүл монгол хүн" үндэсний чуулганаас гарсан зөвлөмжийн хэрэгжилт Хавсралт: 7 файл		
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг	Бодлогын баримт бичгийн хугацаандаа	2023 оны хэрэгжилт	Засгийн газрын үйл ажиллагааны	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн 2023 оны	1-р сар, 2-р сар, 3-р сар,	Өөрийн үнэлгээ: 90%

	хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг сар, бүтэн жилээр тайлагнах	тайлагнасан хэрэгжилтийн хувь		хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг яамны холбогдох нэгжүүдээс авч, нэгтгэн боловсруулж сар бүр, хагас жилээр хугацаанд нь чанартай тайлагнасан байна.	жилийн эцсийн тайлангийн үнэлгээнд ЗГХЭГ-аас аудит хийсэн бөгөөд тус аудитэд шаардлагатай мэдээ мэдээлэл, судалгааг гаргаж өгөх ажлыг хийсэн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 95 заалтын хэрэгжилтийн биелэлтийн 2024 оны 2,3,4,5 дугаар сар болон хагас жилийн тайланг яамны газар, хэлтсүүдээс http://meds.igovernment.mn/ буюу салбарын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаар дамжуулан авч боловсруулалт хийж нэгтгэн ХШҮДАГ-т хугацаанд нь илгээсэн. МУ-н Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны тайлангийн 16 заалт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2 заалт тус бүрд эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний хэрэгжилтийг хангах тайлбар авч нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. 2024 оны 11 сард Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааг гарган ХШҮДАГ-т хүргүүлсэн. Хавсралт: 3 файл	4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
3	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны хэрэгжилт	Боловсролын салбарын түвшинд хүчин төгөлдөр мөрдөж буй үндэсний хөтөлбөрүүд, Монгол Улсыг	Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичгийг 2 жил тутам (тэгш онд) тайлагнан гаргадаг. Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн 2023 оны байдлаар явцын хэрэгжилтийг яамны нэгжүүдээс Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан буюу	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн

	хэмжээний хэрэгжилтийг тайлагнах;			хөгжүүлэх үндсэн чиглэл, хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, биелэлтийг нэгтгэн, тайланг хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн байна.	http://meds.igovernment.mn системээр дамжуулан авч 58 арга хэмжээг нэгтгэн боловсруулж ХШҮДАГ хүргүүлсэн. 2024 оны хэрэгжилтийн тайлан систем дээр нээгдээгүй байна. Хавсралт: 1 файл		даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
4	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах;	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	-	Боловсролын салбарын түвшинд хүчин төгөлдөр мөрдөж буй үндэсний хөтөлбөрүүд, Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, биелэлтийг нэгтгэн, тайланг хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн байна.	Монгол Улсыг хөгжүүлэх 2023 оны төлөвлөгөө, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн тайлангийн хэрэгжилтэд аудит хийсэн бөгөөд тус аудитад мэдээ мэдээлэл цаг тухайд нь гаргаж өгөх ажлыг гүйцэтгэсэн. МУ-н Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн “Зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2 заалт, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 заалт тус бүрд эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний хэрэгжилтийг хангах тайлбар авч нэгтгэн ХШҮГ-т хүргүүлсэн. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн үнэлгээтэй холбогдуулан хийх нэмэлт тайлбар, нотлох баримт, хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэлтэй асуудлын талаар заалт тус бүрд мэдээлэл гаргуулан авч нэгтгэн ЭЗХЯ руу илгээсэн. Тайлбар: 2024 оны Монгол улсын хөгжлийн төлөвлөгөө системд ороогүй учир тайлагнах боломжгүй байгаа болно. Хавсралт: 3 файл	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

1.2. Яамны үйл ажиллагааны өдөр тутмын тогтвортой, тасралтгүй байдлыг хангах, төрийн захиргааны байгууллага, харьяа байгууллагын болон салбарын хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, манлайллаар хангах, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг, үйлчилгээ үзүүлнэ.

5	Боловсролын яамны Төсвийн ерөнхийлөн захирагч-шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Яамны нэгжийн болон албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулах, тайлагнах, урамшуулах ажлыг зохион байгуулах;	Боловсролын яамны албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, урамшуулалын хувь	2023 оны гүйцэтгэл	Яамны албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангуулах, үнэлж дүгнэн хариуцлага тооцох, урамшуулах шийдвэр гарсан байна.	1.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төсвийн ерөнхийлөн захирагч-шууд захирагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэ бүтцийн хүрээнд 35 зорилт 180 арга хэмжээтэй боловсруулан цахим системд бүртгэн оруулж батлуулах ажлыг зохион байгуулсан. Зохион байгуулалтын нэгжийн 12 газар, 8 хэлтсийн төлөвлөгөөг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж батлуулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласан. Төрийн жинхэнэ албан хаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг албан хаагч нар боловсруулан батлуулах ажлын системийн эрхийн зохицуулалт хийж ажилласан. 2.Боловсрол, шинжлэх ухааны яамны албан хаагчдын 2024 оны хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх үнэлгээний багийн нарийн бичгээр томилогдон ажилласан. Нийт 92 албан хаагчийн үнэлгээг системд оруулан, хэвлэж баталгаажуулсан. 2.Боловсролын яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэ бүтцийн хүрээнд шинэчлэн батлуулах зорилгоор нэгжүүдээс яамны төлөвлөгөөнд тусгах ажлын саналыг авч 30 зорилт 154 арга хэмжээтэй боловсруулан цахим системд бүртгэн оруулсан. Хавсралт: 6 файл	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
6	Салбарын хяналт шинжилгээ,	Хяналт шинжилгээ,	2023 оны гүйцэтгэл	Байгууллагын түвшинд Хяналт	Зохион байгуулалтын нэгжийн 10 газар, 8 хэлтсийн төлөвлөгөөг яамны гүйцэтгэлийн	1-р сар, 2-р сар,	Өөрийн үнэлгээ: 100%

	үнэлгээний мэдээллийн цахим системийг нэвтрүүлэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх. яамны шилжилт хөдөлгөөний эрхийн зохицуулалт хийх	үнэлгээний мэдээллийн цахим системд эрхийн зохицуулалт хийсэн мэдээллийн тоо		шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим системийн ашиглалт сайжирсан байна.	төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах ажлын системийн эрхийн зохицуулалт хийж ажилласан. Мөн яамны нийт албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахимд оруулах системийн эрхийн зохицуулалт хийсэн. https://meds.igovernment.mn/home/ системд харъяа байгууллагын болон 21 аймаг нийслэлийн боловсролын газрын төлөвлөгөөг хяналтаас хассан. Дахин боловсруулж оруулах чиглэл хүргүүлсэн. Боловсролын яамны бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан салбарын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд байгууллагын шинэ бүтцийн албан хаагч нарын мэдээллийг шинэчлэн системийн удирдлагад илгээсэн. Шинээр томилогдсон адбан хаагч нарын эрхийн зохицуулалтыг тухай бүр хийн ажиллаж байна. 2024 онд 172 удаагийн үйлдлээр системд хандсан байна. Сайдын шуурхайн үүрэг даалгаврын биелэлтийг систем ашиглан тайлагнаж байна. Харьяа байгууллагуудын төлөвлөгөө тайланг тус системээр батлан хэрэгжилтийг дүгнэх, үнэлэх ажлыг гүйцэтгэж байна. Хавсралт: 3 файл	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
7	Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Аймаг, нийслэлийн засаг даргын хооронд 2024 онд орон нутагт боловсрол, шинжлэх ухааны	Гэрээний тоо	2023 оны гүйцэтгэл	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан аймаг, нийслэлийн засаг дарга нартай 2024 онд орон нутагт боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Төрийн ордны Их засаг танхимд зохион байгуулсан. Тус гэрээний төслийг 21 аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын

	салбарт хамтран ажиллах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулалтаар ханган ажиллах				бодлогын холбогдох газруудаас санал авч нэгтгэн БНБТГ-тай хамтран боловсруулан батлуулсан. Хавсралт: 3 файл		үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
8	“Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл” болон “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл”-ийн ажлын төлөвлөгөөний төсөлд санал өгөх, хариуцсан заалт тус бүрээр нь хэрэгжилтийг гаргах ажлын хэрэгжилтийг ханган ажиллаллах;	Төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	2023 оны гүйцэтгэл	Төлөвлөгөөний хэрэгжилт хугацаандаа хүргэгдсэн байна.	1.Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж хүргүүлсэн. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан хүргүүлсэн. 2.Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан боловсролын салбарын бэлэн байдлыг хангах хүрээнд өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, сургуулийн хичээл сургалтын үйл ажиллагаанд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн боловсролын газрын дарга нарт үүрэг болгон БШУС-ын 2024.02.22-ны өдрийн А/75 дугаар тушаалаар чиглэл хүргүүлэн ажилласан. Орон нутгийн цаг агаарын нөхцөл байдал болон мал аж ахуйн салбарт үүссэн хүндрэл, улс, орон нутгийн чанартай зам, даваа хаагдсаны улмаас хичээл, сургалтын үйл ажиллагаа доголдох, барилга байгууламжийн аюулгүй байдал, цахилгаан хангамж, халаалт-дулаан алдагдах, түлш, хүүхдийн хоол хүнс хомсдол үүсэх зэрэг хүүхэд	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хамгааллын асуудлаар судалгаа авч холбогдох мэдээллээр ханган ажиллаж байна. Боловсролын салбарын хэмжээнд малчдад туслах хандивын аян өрнүүлж нийт 16 байгууллагын албан хаагчдаас “НЭГ ӨДРИЙН ЦАЛИН” хандивын аяны хүрээнд цугларсан бэлэн мөнгийг Онцгой байдлын ерөнхий газрын Хандивын (Хаан банкны 5263315732) тоот харилцах дансанд шилжүүлэх ажлыг зохион байгуулалтаар ханган ажилласан. 3.Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр, Гамшгийн эрсдэлийг бууруулах сендайн үйл ажиллагааны хүрээг монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх II үе шат (2021-2025)-ны арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг гарган ОБЕГ-т хүргүүлсэн. 4.Онцгой байдлын байгууллагын 20 жилийн ойн хүрээнд “Гамшгийн эрдслийг бууруулах шинжлэх ухаанч санаачлага-2” сэдэвт үндэсний уралдааны талаарх мэдээллийг Боловсролын яамны цахим хуудсанд нийтэлсэн. Хавсралт: 5 файл		
9	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг яамны хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллах	Зохион байгуулсан ажлын тоо	-	Зааварчилгаа боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг ТНБД-ын 2024.04.05-ны өдрийн А/70 тоот тушаалаар байгуулсан. Дотоод аудитын хэлтсийн шинжээч М.Нямханд нь 2024.03.27-ны өглөө ажилдаа ирж, орох хаалганы дотор талд халтирч унан хөлөө хугалсан тул Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн 2.1.5 дугаар	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн

					заалтын дагуу үйлдвэрлэлийн осолд тооцож холбогдох бичиг баримт материалыг бүрдүүлэн СБД-н Хөдөлмөрийн /хөдөлмөрийн эрүүл ахуйн/ хяналтын улсын байцаагч Ч.Отгонжаргалд хүргүүлэн батлуулж om.inspection.gov.mn цахим хуудсанд бүртгүүлэн баталгаажуулсан. Тус материалын хувийг СБД-ийн нийгмийн даатгалын байцаагчид хүргүүлсэн бөгөөд Шинжээч М.Нямхандад Нийгмийн даатгалаас хөдөлмөрийн чадвараа түр алдсны тэтгэмж олгосон. 2. “Боловсрол, шинжлэх ухааны яамны албан хаагчдын аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-г боловсруулан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын даргаар батлуулан able системийн https://intranet.gov.mn/main.php?p=cHiVbGlj Олон нийт хэсгийн мөрдөх журам заавар цэсэд байршуулсан. 3. “Албан томилолтоор ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа”, “Албан томилолтоор ажиллах тээврийн хэрэгслийн жолоочид өгөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа”-ны төслийг боловсруулан ТНБД-н А/14 дүгээр тушаалаар батлуулан мөрдүүлэн ажиллаж байна. 3. Бүх төрлийн ажлын байранд ажиллагчдад аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н суурь болон хууль эрх зүйн ойлголтыг өгөх зорилгоор 2024.04.30-ны өдөр Мэдээллийн цагаар ХАБЭСТ-ийн сургалт хариуцсан мэргэжилтэн Х.Дарьсүрэн "Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал"-р	12-р сар	хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	----------	--------------------------------------

					яамны болон БЕГ-н нийт албан хаагч нарт сургалт хийх ажлыг зохион байгуулсан. 4.“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2024” арга хэмжээний хүрээнд боловсролын салбарт зохион байгуулсан ажлын тайланг ХНХЯ-нд хүргүүлсэн. Хавсралт: 6 файл		
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
10	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	Батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас, бүтэн жилийн тайлан, бэлтгэсэн мэдээлэл, архивын нэгж	2023 оны гүйцэтгэл	ТАХ-ийн гүйцэтгэлийн сүүлийн хагас жилийн биелэлтийг тайлагнасан, мэдээллийг цаг тухайд бэлтгэсэн байна.	1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаанд нь боловсруулж батлуулсан. Сарын хийсэн ажлын тайланг тухай бүр оруулж баталгаажуулсан. 2. Сайдын шуурхай хурлын үүрэг даалгаврын 2024 оны хэрэгжилтийг http://meds.igovernment.mn/ буюу салбарын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаар дамжуулан авч нэгтгэн мэдээлэл танилцуулга бэлтгэн ХШҮГ-т хүргүүлсэн. 2024 онд Сайдын шуурхай 22 хурал зохион байгуулж нийт 195 үүрэг даалгавар өгсөн байна. 3. Боловсролын яасны албан тушаалын тусгай шалгалт зохион байгуулах сонгон шалгаруулалтын 3 ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажилласан. 4. Боловсролын яам, Шизүока мужийн Боловсролын газар, Дорноговь аймгийн ЗДТГ хооронд байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд "Багш, сурагч солилцооны хөтөлбөр"-ийн хүрээнд шалгарсан 25 сурагчийг удирдан Япон улсын Шизүока мужид 10 сарын 23-28 өдрүүдэд томилолтоор ажиллаад ирсэн. Хавсралт: 5 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

11	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	Хугацаанд нь шийдвэрлэсэн албан бичиг, өргөдөл гомдлын тоо	2023 оны гүйцэтгэл	Албан бичиг, өргөдөл, санал хүсэлтийг журамд заасан хугацаанд хариу өгсөн байна.	1. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр хугацаанд нь мэдүүлсэн. 2. Дараах баримт бичгийг архивийн нэгж болгон хүлээлгэн өгсөн. 1.Боловсрол, шинжлэх ухааны сайд болон аймаг нийслэлийн засаг даргын хооронд 2023 онд орон нутагт боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээ /Нийслэл, 21 аймаг/ 2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан 3. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн тайлан 4. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний тайлан 5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлан 3. Нийт 63 албан бичиг, 12 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд нь хариу өгч ажилласан. Нийт 8 тушаал боловсруулан батлуулсан. 4. “Боловсрол, шинжлэх ухааны салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг, үнэмлэх, хавтас нийлүүлэх” тухай, “Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажиллаж байсан сайд нарын хөрөг зураг зурах” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, “Монголын багш нарын VIII их хурлын оролцогч нарт тараах материалын багц” худалдан авах, Монголын багш нарын VIII их хуралд хэрэглэх бичиг хэргийн хэрэгсэл худалдан авах тухай, “Боловсролын салбарын эрсдэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нийт 5 тендерийг амжилттай зохион байгуулж гэрээ байгуулах мэдэгдэл олгосон.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
----	---	---	---------------------------	---	---	---	--

					Хавсралт: 7 файл		
--	--	--	--	--	------------------	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Салбарын болон Төрийн албаны хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг судалж мөрдөж ажиллах	Шинэчлэгдэн батлагдсан шаардлагатай баримт бичгийг судалж мөрдөж ажиллана.	2023 оны гүйцэтгэл	Төрийн албаны тухай болон боловсролын чиглэлээр шинээр болон шинэчлэгдэн гарсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг судалсан байна.	1. 2024 оны 3 дугаар сарын 4, 5-ны өдрүүдэд зохион байгуулсан “МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ХУВИРГАН ӨӨРЧЛӨЛТ” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН 2024”-д оролцсон. 2. Төрийн албаны зөвлөлөөс 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"ийн танилцуулга сургалтад хамрагдсан. 3. Төрийн албаны зөвлөлөөс 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан "Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					мэдлэгт орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж буй туршлага, ололт амжилт, цахим орчинд шилжиж ажиллах" сэдэвт сургалтад хамрагдсан. 4. 2024 оны 03 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд Удирдлагын академиас зохион байгуулсан "Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, үнэлэх аргачлал" сэдэвт нийт 16 цагийн богино хугацааны танхимын сургалтад хамрагдаж үнэмлэх авсан. 5. 2024 оны 04 дүгээр сарын 30-наас 05 дугаар сарын 21-ний өдрийг дуустал Аж ахуйн нэгж байгууллагын түвшинд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцан ажиллах ажилтныг бэлтгэх зорилготой 124 цагийн Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай онолын мэдлэг, практик дадал эзэмшүүлэхэд чиглэсэн агуулга, хөтөлбөртэй "ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалт"-д хамрагдаж амжилттай төгсөн сертификат авсан. 5. 2024 оны 11 дүгээр сард Удирдлагын академаас зохион байгуулсан "Төрийн албаны удирдах албан тушаалтны ур чадварыг хөгжүүлэх нь" сэдэвт сургалтад хамрагдаж сертификат авсан.	
--	--	--	--	--	--	--

					Хавсралт: 5 файл		
2	Байгууллагын мэдээллийн цаг, бусад холбогдох сургалтад хамрагдана.	Мэргэжил дээшлүүлэх сургалт, мэдээллийн цагт хамрагдана.	2023 оны гүйцэтгэл	Байгууллагын мэдээллийн цаг, бусад холбогдох сургалтад бүрэн хамрагдсан байна.	1. Мэдээллийн цагийн хуваарийн дагуу 2024.03.26-ны өдөр зохион байгуулсан "21 дүгээр зууны боловсрол-Насан туршийн суралцахуй" сэдэвт мэдээлэллийн цагт хамрагдсан. 2. Мэдээллийн цагийн хуваарийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан Нура төвийн их эмч С.Цэрэнпагма "Витаминны хэрэглээ болон багц оношилгооны талаар" сэдэвт мэдээллийн цагт хамрагдсан. 3. Мэдээллийн цагийн хуваарийн дагуу 2024.05.22-ны өдөр зохион байгуулсан Философийн хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга М. Анара (Ph.D) "Албан хаагчийн сэтгэл зүйн эрүүл мэндийн үндэс: стресс менежмент" сэдэвт мэдээллийн цагт хамрагдсан. 4. Мэдээллийн цагийн хуваарийн дагуу дараах сургалтад хамрагдсан. "Үндэсний бичгийн анхан, дунд, ахисан түвшний сургалт", "Хөгжил ба мэдлэг" "Боловсролын салбарын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөлөл", "Боловсролын яамны албан хэрэг хөтлөлтийн журмын тухай баримт бичгийн боловсруулалтын явц" 4.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85%

					Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтад бүрэн хамрагдсан. Хавсралт: 7 файл		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Төлөвлөлт, тайлагналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Пүрэвжав Наранжаргал /...../

Огноо:

.....